

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ
/ 2018.01.01-2019.01.01/**

№	Хөтөлбөрийн танилцуулга хэсэг	
1.	Хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар	Улсын Их Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 114 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”
2.	Хөтөлбөрийн зорилго	Төрийн байгууллага, албан тушаалтан, хувийн хэвшил, иргэний нийгэм, улс төрийн нам, бүлгийг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, олон нийтэд шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх, ил тод, нээлттэй, хариуцлагатай нийгмийг хөгжүүлэх
3.	Санхүүжилтийн эх үүсвэр	Улсын болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгө
4.	Хэрэгжүүлэгч байгууллага	Бүх шатны төрийн байгууллага
5.	Хэрэгжих нийт хугацаа	6 жил
6.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	<p>Зорилт 1. шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p>Зорилт 2. төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 3. төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 4. худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлж, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 5. шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга, ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх, авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах;</p> <p>Зорилт 6. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх;</p> <p>Зорилт 7. авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих;</p>

		<p>Зорилт 8. иргэний мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан хуулийн хэрэгжилтийг хангах, хэвлэл мэдээллийн эрх зүйн орчин, сэтгүүлчийн мэргэжлийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 9. улс төрийн намын болон сонгуулийн санхүүжилтийг олон нийтэд ил тод, нээлттэй болгох, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллагыг улс төр, бизнесийн бүлэглэлийн хууль бус ашиг сонирхол, нөлөөллөөс ангид байлгах;</p> <p>Зорилт 10. шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх;</p> <p>Зорилт 11. авлигатай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хүрээнд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсын байгууллагын санал, зөвлөмжийг авч хэрэгжүүлэх.</p>		
7.	Зардал	Төсөв	24,962.4	
		Үүнд:	Төсөв	Гүйцэтгэл
		1-р үе шат	14,308.9	499.0
		2-р үе шат	10,653.5	-
Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах хэсэг				
Төсөл, хөтөлбөрийн зорилт:	Гүйцэтгэлийг Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор баталсан төлөвлөгөөний арга хэмжээ бүрээр, хүрсэн түвшин, үр дүнгийн үзүүлэлтийн хамт зохих талбарт бичнэ.			
1-р зорилтын хүрээнд:	<p>Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх;</p> <p>Тус байгууллагаас 2018 онд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ “Авлига, албан тушаалтны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2018 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны төлөвлөгөөг гарган 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр; ➢ “Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр 2018 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны төлөвлөгөөг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдөр тус тус байгууллагын даргаар батлуулан нийт албан хаагчдад танилцуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн, биелэлтийг ханган ажилласан. <p>Төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тайлант онд албан хаагчдыг ажлын байрны тодорхойлолтод заасан мэдлэг, боловсрол, ур чадварыг нь харгалзан шинээр болон дэвшүүлэн томилохын зэрэгцээ гадаад болон дотоод сургалтад хамруулан мэдлэг боловсролыг нь дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа.</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/227 дугаар тушаалаар “Гадаадын иргэн, харьяатын газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц”-ийг 310</p>			

албан хаагчийн орон тоотойгоор шинэчлэн баталсан бөгөөд үүнээс төрийн захиргааны-187, төрийн үйлчилгээний -85 албан хаагч байна. Тайлант хугацаанд буюу 2018 оны 01 дүгээр сарын 01-нээс 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийг хүртэлх хугацаанд төрийн албаны жинхэнэ албан тушаалын ажлын байранд иргэнийг гэрээгээр ажиллуулсан болон орон тооны хязгаарыг хэтрүүлэн албан тушаалд томилсон зөрчил гараагүй болно. Мөн төрийн захиргааны албан тушаалд шинээр томилох тухай 21, дэвшүүлэн томилох тухай 27, албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх тухай 8, шилжүүлэн томилох тухай 16, сэлгэж ажиллуулах тухай 1, хүүхэд асрах чөлөөг дуусгавар болгож ажилд эгүүлэн томилох тухай 3, шүүхийн шийдвэрээр өмнөх албан тушаалд эгүүлэн томилох тухай 1 нийт 77 ажилтан, албан хаагчийн асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагын даргын тушаалаар томилсон. Төрийн албан хаагчийг шинээр томилохдоо төрийн албаны шалгалт өгч тэнцсэн байдлыг харгалзан үзэж Авлигатай тэмцэх газар болон Төрийн албаны зөвлөлд холбогдох материалыг хүргүүлэн хянуулж төрийн албан хаагчийн тангараг өргүүлснээр төрийн захиргааны албан тушаалд томилж хэвшсэн. Мөн тус байгууллага нь албан тушаалтанд тавигдах ёс зүй, мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг шинэчлэх ажлын хүрээнд “Ажлын байрны тодорхойлолт шинэчлэн батлах тухай” байгууллагын даргын 2018 оны 12 дугаар сарын 24-ны өдрийн А/441 дугаар тушаалаар нийт албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталсан бөгөөд дээрхи тодорхойлолтод заасан шалгуурыг үндэслэн төрийн албанд томилох, дэвшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх Төрийн албаны Салбар зөвлөл, Төрийн албаны зөвлөлтэй хамтран Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газар, Өмнөд бүс дэх газар болон Говь-Алтай, Сүхбаатар аймаг дахь хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах албан хаагчдын сонгон шалгаруулалтыг 2018 оны 01 дүгээр сард, Дорноговь аймаг дахь газрын даргын албан тушаалд томилогдох удирдах албан хаагчдын сонгон шалгаруулалтыг мөн оны 9 дүгээр сард, Зүүн бүс дэх газрын даргын албан тушаалд томилогдох удирдах албан хаагчийн сонгон шалгаруулалтыг мөн оны 12 дугаар сард тус тус зохион байгуулж Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан. Мөн Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газарт мэргэжилтний ажлын байрны сул орон тооны захиалгыг 2018 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр Гадаадын иргэн, харьяатын газрын цахим хуудас /www.immigration.gov.mn/-т болон Төрийн албаны зөвлөлийн цахим хуудас /www.csc.gov.mn/-т болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулсан, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлан мэдээлж ажиллав. Тайлант хугацаанд 18 албан хаагчид гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн эрх, 6 албан хаагчид гадаадын иргэнд олгох виз, хувийн урилгад батламжлан гарын үсэг зурах эрх тус тус олголоо. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1995 оны 109 дүгээр зарлигаар баталсан “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”-ын дагуу төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэн нийт 17 албан хаагчийг төрийн жинхэнэ албан хаагчид хамруулав. 2018 онд Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Катар Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Тайвань гэсэн 5 улсад богино хугацааны сургалтад 11 албан хаагч хамрагдаж, урт хугацааны сургалтад 7 албан хаагч хамрагдсан буюу нийт 18 албан хаагч уригч байгууллагын зардлаар гадаад сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. Түүнчлэн нийтийн албанд албан тушаалтныг томилох эрх бүхий албан тушаалтнаас тус байгууллагад албан хаагчдыг шинээр томилох, ажлын байрыг шилжүүлэн болон сэлгүүлэн ажиллуулах, дэвшүүлэн томилохдоо УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах журмын 3.6-д заасны дагуу тухай бүр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн ажиллав. Тус байгууллагын харьяа салбар, нэгж байгууллагын хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг 2018 оны 01 дүгээр 04-ны өдрийн 1-06/35 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэст хүргүүлсэн. Дээрхи нэрсийн жагсаалтын дагуу тус байгууллагын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг үүрэг гаргах үүрэг бүхий нийт 195 албан

	<p>тушаалтны /шинэчлэн гаргасан-192, шинээр томилогдсон-3/ 2017 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд буюу 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор хүлээн авч, бүртгэн, баталгаажуулж мөн оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 1-06/444 дугаар албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлэв. Мөн 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд нийт 71 албан тушаалтны /шинээр томилогдохоор нэр дэвшсэн 35, дэвшин томилогдохоор нэр дэвшсэн 20, шилжин томилогдохоор нэр дэвшсэн 16/ хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллав. Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахгүйгээр томилох, томилсны дараа хянуулах зөрчил гараагүй болно. Мөн шинээр томилогдсон 60, их хэмжээний өөрчлөлтөө мэдүүлсэн 6 нийт 66 албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг хуулийн хугацаанд хүлээн авч, баталгаажуулж ажилласан. Түүнчлэн тус байгууллагын албан тушаалтнууд нь хяналт шалгалт хийх, шийдвэр гаргах, худалдан авах ажиллагаанд оролцох, гэрээ хэлэлцээр хийхдээ ашиг сонирхлын зөрчилтэй болон зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл тайлбарыг өгч хэвшсэн ба 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 10-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 143 албан тушаалтнаас ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл, тайлбарыг авсан бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргасан албан тушаалтан 1 байна.</p>
2-р зорилтын хүрээнд:	<p>Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг нь сайжруулах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх;</p> <p>Тус байгууллага нь 2017 оноос эхлэн “Цахим иммигрэйшн” зорилтыг дэвшүүлэн ажилласан бөгөөд визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох, хариу өгөх үйлчилгээг цахим болон мессэж хэлбэрээр хүргүүлэх үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн. 2018 онд evisa.mn цахим системийг шинэчлэн сайжруулж иргэдээс цахимаар виз, визийн зөвшөөрөл, хувийн урилга олгох үйл ажиллагааны материал бүрдүүлэлтийг цахимаар хүлээн авах боломжтой болгосон. Энэхүү ажлын хүрээнд түр ирэгч, албан болон хувийн хэргээр оршин суухаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хүсэлтийг үндэслэн нийт 24190 визийн зөвшөөрөл, 18182 визийг тус тус олгосон байна. Мөн тус байгууллагаас 19036 гадаадын иргэний визийн зөвшөөрлийг Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газарт цахим шуудан, факсаар илгээсэн байна. Хилийн боомтод олгох 5154 гадаадын иргэний визийн зөвшөөрлийг хилийн боомтуудад илгээсэн. Гадаадын болон өөрийн орны иргэдээс хувийн журмаар гадаадын иргэдийг урих хүсэлтийг хянан 376 гадаадын иргэнд Монгол Улсад хувийн хэргээр зорчих урилга олгосон байна. Түүнчлэн иргэдийн асуултад онлайн хэлбэрээр нийт 260 иргэнтэй тухай бүр цахимаар харилцан хариуг өгч, хилийн боомт, бүсийн газруудыг виз, бүртгэлийн чиглэлээр байнгын удирдлагаар хангахын зэрэгцээ хилийн боомт, бүсийн газруудаас факс, цахим шуудан, мессежээр ирүүлсэн хасалт хийсэн тухай тэмдэглэлийг тухай бүр мэдээллийн санд оруулж ажилласан. Мөн уг системд тоон гарын үсгийг нэвтрүүлж эхлээд байна. Тус байгууллагын Дундговь, Говь-Сүмбэр, Завхан, Баянхонгор аймаг, Дорноговь аймгийн Сайншанд дахь төлөөллийг байгууллагын нэгдсэн сүлжээнд холбох ажлыг зохион байгуулсан. Мөн “evisa.mn” системийн өргөтгөл сайжруулалтын чиглэлээр 2 багцын хүрээнд 274,8 сая төгрөгийн программ хангамж, тоног төхөөрөмж, мөн байгууллагын интернет болон дотоод сүлжээний аюулгүй байдлыг сайжруулж хамгаалалтыг нэмэгдүүлэх чиглэлээр 159,9 сая төгрөгийн багаж, техник хэрэгслийг худалдан авах ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан бөгөөд программ хөгжүүлэлтийн ажлын гүйцэтгэл 95 хувьтай хэвийн үргэлжилж байна. Мөн “evisa.mn” цахим хуудасны “SSL” хамгаалалтыг тохируулж аюулгүй байдлыг хангах, сүлжээний хяналтын системийг сайжруулах үүднээс “PingPro” програм хангамжийг шинээр хөгжүүлэн бүрэн хяналт тавьж ажиллаж байна. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай 2018 оны 03 сард уулзалт зохион байгуулж харилцан солилцож буй мэдээллүүдээс /албан тоот/ цахимаар солилцох боломжтой хэд байгааг тодорхойлж 2 байгууллагын бүхий л албан бичгийг цахим болгох бүрэн боломжтой</p>

		<p>талаар ойлголцолд хүрсэн. 2018 оны 06 дугаар сарын 22-ны өдөр Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын төлөөлөлтэй уулзалт хийв. Уулзалтаар гадаадын ажиллах хүчний мэдээллийн сан нь төрийн мэдээллийн “ХУР” системд холбогдосон эсэх тухай тодруулсан бөгөөд 2019 оны 1-р улиралд Тагнуулын ерөнхий газартай онлайнаар мэдээлэл солилцох бүрэн боломжтой талаар зөвшилцөлд хүрч системийн хөгжүүлэлтийг бүрэн хийж бэлэн болгоод байна. Мөн “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 01/117 дугаар тушаалаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газартай “Мэдээлэл солилцох стандарт”-ыг баталсан бөгөөд хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Түүнчлэн 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдөр “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын “ХУР” төрийн мэдээллийн солилцооны системд холбогдох гэрээг байгуулсан бөгөөд мөн оны 11 дүгээр сараас гэрээний хэрэгжилтийг ханган тус системд холбогдон мэдээлэл солилцож эхлээд байна. Цагдаагийн ерөнхий газар, Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл, Төрийн мэдээлэл холбооны газар, Интерполын үндэсний агентлаг, Хил хамгаалах ерөнхий газар зэрэг байгууллагуудын эрх бүхий тушаалтнуудын уулзалт 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулагдаж, Интерполын үндэсний агентлагтай мэдээллийн системүүдийг холбоход шаардлагатай мэдээ, мэдээллийг Хил хамгаалах ерөнхий газраас бэлтгэн хүргүүлэхээр тохиролцсон. Мөн онд багтаан Монгол Улсын нэр бүхий 3 боомт дээр интерполын мэдээллийн сан бүхий “ISM” систем ажиллах боломжтой байхаар төлөвлөж, Хил хамгаалах байгууллага, тус байгууллагаас хамтарсан ажлын хэсгийн гишүүд төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Тус байгууллагаас Интерполын үндэсний товчоотой холбох сүлжээний сувагчлалыг ХХЕГ-т байрших “ISM” системтэй холбох бэлтгэл ажлыг бүрэн хангасан бөгөөд Монгол Улсад Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл болон Интерполын үндэсний агентлагтай байгуулах мэдээлэл харилцан солилцох гэрээг байгуулсан. Тус арга хэмжээний хэрэгжилт нь Интерполын үндэсний товчоо болон ХХЕГ-аас шалтгаалан удаашралтай байна. Дээрх системүүдтэй “ISM” системийг Хил хамгаалах байгууллага холбогдсоны дараа чиг үүргийнхээ дагуу үйл ажиллагаандаа ашиглаж, олон улсад эрэн сурвалжилж буй иргэний мэдээллийг харах боломжтой болох юм.</p>
3-р зорилтын хүрээнд:		<p>Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх; Санхүүгийн чиглэлээр- Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2018 оны төсөв 6,4 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 11 дугаар сарын байдлаар нийт 6,3 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдож зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцууллаа. Орон нутаг дахь газрын дарга буюу төсвийн шууд захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл болон төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас аудит хийж “Зөрчилгүй санал дүгнэлт” авсан. 2018 онд төв болон орон нутаг дахь газрууд харилцагч байгууллагуудтай ямар нэгэн өгөх өр төлбөр, авах авлагагүй ажилласан. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өссөн дүнгээр 3 798 9 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 510 8 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 204 1 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласан. Тайлант хугацаанд төрийн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлсөн бөгөөд үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлсний улмаас төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан тохиолдолд байхгүй болно. Тайлант хугацаанд төрийн захиргааны 25 албан хаагчийг өөрийн гаргасан хүсэлтийн дагуу, 1 албан хаагчийг сахилгын шийтгэлээр, төрийн үйлчилгээний 9 ажилтанг өөрийн гаргасан хүсэлтийн дагуу, 1 ажилтанг сахилгын шийтгэлээр, 3 албан хаагчийн хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон тул төрийн албанаас чөлөөлсөн байна. Мөн албан хаагчдын ажлын байрыг эрүүл ахуйн стандартын дагуу тохижуулах ажлын хүрээнд байгууллагын төвийн “Б” байрны дээврийн засварын ажлыг 39,3 сая төгрөгийн, сантехник дулааны шугам сүлжээнд халаалтын иж бүрэн магистрал шугамын ажлыг 11,1 сая төгрөгийн, байгууллагын гадна талын шилэн хана, спорт заалны цонхны цэвэрлэгээг</p>

		<p>985 мянган төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээ байгуулан гүйцэтгүүлээ. Дорноговь аймаг дахь газар нь албаны байр болон дулааны шугам сүлжээнд нийт 9,8 сая төгрөгийн засвар үйлчилгээг хийсэн бөгөөд дээврийн засварын ажлыг ирэх онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийлгэхээр шийдүүлсэн. Түүнчлэн байгууллагын дотоод нөөц бололцоог дайчлан спорт заалны иж бүрэн засварыг хийж гүйцэтгэлээ. Батлагдсан төсвийн хүрээнд албаны дүрэмт хувцасны нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж 246,7 сая төгрөгийн хангалтыг хийлээ. Мөн гадаадын иргэдэд Монгол үндэсний өв соёл, уламжлалыг сурталчлан таниулах, гадна, дотнын зочид төлөөлөгчдийг хүлээн авах үйл ажиллагаанд зориулан “Хүндэтгэлийн өргөө”-г барьж тохижуулсан. Автомашины парк шинэчлэх ажлын хүрээнд Орон нутгийн өмчийн хөрөнгөөр туулах чадвар сайтай автомашин худалдан авч, төвийн үйл ажиллагаанд хэрэглэж байсан автомашиныг Дорноговь аймаг дахь газарт шилжүүлж, тус газрын туулах чадвар сайтай автомашиныг Баруун бүс дэх газарт шилжүүлж, орон нутгийн бүртгэлд бүртгэж улсын дугаар олгох арга хэмжээг зохион байгуулж ажилласан.</p> <p>Дүн шинжилгээ, аюулгүй байдал, аудитын чиглэлээр: Хяналт-шинжилгээ, үнэлгээг нийт 39 удаа хийн тайланг гаргаж, тухай бүр удирдлагад илтгэх хуудсаар танилцуулж ажиллав. Мөн дотооддоо төлөвлөгөөт 2, төлөвлөгөөт бус 13 шалгалт хийж гүйцэтгэн шалгалтын тайланг удирдамжид заасан хугацаанд илтгэх хуудсаар танилцуулан холбогдох чиглэл авч ажиллав. Дотоод аудиторын 2018 оны төлөвлөгөөний дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр 12, нийцлийн чиглэлээр 5, нийт 17 удаагийн төлөвлөгөөт дотоод аудитын шалгалтыг хийж гүйцэтгэн, материаллаг бус 69 асуудлыг илрүүлж, 21 асуудлыг аудитын явцад хэрэгжүүлэн ажиллаж, нийт давхардсан тоогоор 48 зөвлөмж хүргүүлж, ажлын үр дүнг тухай бүр тооцож ажилласан бөгөөд зөвлөмжийн хэрэгжилт 90 хувийн үзүүлэлттэй байна. Гадаадын иргэн, харьяатын газрын дарга төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан тэнцэл, тодруулгыг 2018 оны 03 дугаар сарын 05-ны дотор хуулийн хугацаанд гарган Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. Мөн 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс Буянт-ухаа дахь газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд түүврийн аргаар, Гадаадын иргэн, харьяатын газар буюу төсвийн шууд захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл болон Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хамтад нь 2018 оны 03 дугаар сарын 07-25-ны өдрүүдэд аудит хийсэн бөгөөд “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан. Үндэсний аудитын газрын Орон нутаг дахь төрийн аудитын газраас тус байгууллагын Орон нутаг дахь бүсийн 6 газарт “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн бөгөөд нийт газруудад цаашид анхаарч засч залруулах 12 зөвлөмж, 2 албан шаардлага хүргүүлж ажилласан. “Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай” байгууллагын даргын 2018 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 09 дүгээр албан даалгаврыг батлуулан зөрчлийг арилгах, алдааг давтаж гаргахгүй байх талаар хугацаатай үүрэг даалгавар өгч, харьяа газруудад мөн оны 04 дүгээр сард хүргүүлэн 06 дугаар сард зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг гарган ажилласан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 2018 оны 04 дүгээр сард Гадаадын иргэн харьяатын газрын 2017 он болон 2018 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагаанд хийсэн хяналт шалгалтын дагуу санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдэж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримт материалыг бүрдүүлж ажиллан, мөн хөрөнгийн бүртгэлийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хийж, хяналтыг сайжруулах чиглэлээр ерөнхий зөвлөмж өгөгдсөнийг үйл ажиллагаандаа анхаарч хэрэгжүүлэн ажилласан.</p>
7-р зорилтын хүрээнд:		Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийн хяналт, иргэний нийгмийн байгууллагын үүрэг, оролцоог нэмэгдүүлэн, идэвх санаачилгыг дэмжих

		<p>Байгууллагын цахим хуудас /www.immigration.gov.mn/-т “АВЛИГИЙН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЦЭС”-ээр дамжуулан авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой мэдээ, мэдээллийг тухай бүр байршуулан иргэд, аж ахуй нэгж, албан хаагчийг тухай бүр мэдээ мэдээллээр ханган ажиллав. Тухайлбал, цаг үеийн нөхцөл байдлын талаархи мэдээ мэдээлэл 14, Авлигийн эсрэг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт, бусад мэдээ мэдээллийг дээрхи цэсэнд байршуулав. Гадаадын иргэн, харьяатын газрын мэдүүлэг гаргагч албан хаагчдад хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах хугацааны талаарх санамж бүхий 42 секундэн видео шторкийг бэлтгэн, байгууллагын цахим хуудаст байршуулсан. Мөн тус байгууллагын албан хаагчидтай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлийг хүлээн авах зорилго бүхий цахим имэйл хаяг /avliga@immigration.gov.mn/-ийг шинээр нээлгэсэн бөгөөд авлигагаас урьдчилсан сэргийлэх “Санамж”-ийн эхийг бэлтгэн, хэвлүүлж байгууллагын төвийн 1, 2 дугаар байранд байршуулав. Албан хаагчдыг авлига, албан тушаалтны авлигаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагаа, ажилтан, албан хаагчийн ёс зүй, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой саналыг үйлчлүүлэгчээс авах зорилго бүхий “САНАЛ, ХҮСЭЛТИЙН ХАЙРЦАГ”-ийг байгууллагын үйлчилгээний заалны 1 давхарт байршуулж байгаа бөгөөд одоогоор тус хайрцагт үйлчлүүлэгчдээс санал, хүсэлт ирүүлээгүй болно. Мөн тайлант хугацаанд байгууллагын цахим хуудаст 148 мэдээлэл нийтэлснээс 81 мэдээ, 5 ярилцлага, 7 видео бичлэг, үйл ажиллагааны тайлан мэдээ 11, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ 11, төндөрийн шалгаруулалтын 6 зар мэдээг байршуулан олон нийтэд мэдээлж ажилласан байна. Эдгээр мэдээллийг олон нийтийн цахим сүлжээ болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээсэн бөгөөд давхардсан тоогоор 129 цахим хуудас, 31 телевиз, 18 сонин, 3 сэтгүүлд нийтлэгдэв. Түүнчлэн удирдлагын түвшинд барьж буй бодлого, шийдвэрийг олон нийтэд таниулах, сурталчлах ажлыг эрчимжүүлэх, байгууллагын эрхлэх чиг үүрэг, иргэд олон нийтэд үзүүлэх үйлчилгээ, хууль эрх зүйн зохицуулалт, онцлогийг таниулах зорилгоор тодорхой чиглэлүүдээр ярилцлагуудыг бэлтгэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд хүргэв. Тус ажлын хүрээнд 5 ярилцлага, 7 нэвтрүүлгийг бэлтгэн хүргэсэн. Тухайлбал, Монголын үндэсний олон нийтийн телевизтэй хамтран 15 минутын “ Эрх зүйн хөтөч” нэвтрүүлэгт, Eagle телевизийн Мэдээллийн хөтөлбөрийн “Зочны цаг”-т, UBS телевизийн City news мэдээллийн хөтөлбөрийн “Зочны цаг”-т, Монголын үндэсний олон нийтийн телевизийн “Иргэний эрх зүйн боловсролд” нэвтрүүлэгт "Иргэний харьяалал болон гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлүүлэх" сэдвээр, “Эрх зүйн хөтөч” нэвтрүүлгээр “Гадаад иргэдийн хяналт шалгалт” сэдвээр тус тус холбогдох албан хаагч оролцож, байгууллагын үйл ажиллагааг сурталчлан ажиллалаа. Авлигатай тэмцэх газрын даргаас 2017 оны А/185 дугаар тушаалаар “Авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ыг баталсны дагуу Яам, агентлагуудын авлигын эрсдлийн нөхцөл байдлыг дээрхи аргачлалын дагуу үнэлэх ажлыг зохион байгуулсан. Үүний дагуу тус байгууллагад “Авлигын эрсдлийн үнэлгээ”-г зохион байгуулахад төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх Ажлын хэсгийг байгууллагын даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/92 дугаар тушаалаар байгуулан эрсдлийн үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэн ажиллав. Тус байгууллага нь “Монгол гайхамшиг” төрийн бус байгууллагатай хамтран дээрхи үнэлгээг хийсэн бөгөөд 2018 оны 04 дүгээр сарын 30-наас 05 дугаар сарын 08-ны өдрүүдэд үнэлгээний багийн гишүүдэд байгууллагын үйл ажиллагаа, чиг үүрэгтэй хамаарал бүхий нийт 18 төрлийн судалгааг гарган өгч, төвийн нийт албан хаагчдыг авлигын эрсдлийг үнэлэх судалгаанд хамруулах ажлыг зохион байгуулахад хамтран ажилласан. Судалгааны үр дүнгийн талаар 2018 оны 12 дугаар 21-ний өдөр албан хаагчдад мэдээлэл хийн танилцуулсан.</p>
	10-р зорилтын хүрээнд:	<p>Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх; Энэхүү ажлын хүрээнд дараах сургалт, арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна:</p>

		<ul style="list-style-type: none"> ➤ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн талаар болон Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудал сэдвээр 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр төвийн албан хаагчдад; ➤ Шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан сургалтад “Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар болон хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудал” зэрэг сэдвүүдээр 2018 оны 04 дүгээр сарын 10, 12-ний өдрүүдэд; ➤ 2018 оны 09 дүгээр сарын 11, 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулагдсан шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх сургалтад Төрийн албан хаагчийн ёс зүй, Ёс зүйн дүрмийн талаар болон Авлигын эсрэг хууль тогтоомжийн талаар болон хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргахад анхаарах асуудал сэдвүүдээр тус тус хуулийн мэргэжилтэн, эрх бүхий албан тушаалтан М.Золзаяа тус тус сургалт зохион байгуулав; ➤ Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас Авлигатай тэмцэх газрын олон нийтийн төвд зохион байгуулсан “Авлигийн эсрэг багц сургалт”-д 2018 оны 01-12 дугаар сард Гадаадын иргэн, харьяатын газрын Төвийн болон Буянт-Ухаа дахь газрын нийт 102 албан тушаалтныг хамруулах ажлыг зохион байгуулж ажилласан. ➤ Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн “Мэдүүлэг гаргагч нарт зориулсан гарын авлага”, “Авлигийн эсрэг хууль тогтоомжийг таниулах гарын авлага”, “ХАСХОМ гаргахад анхаарах асуудал”, “Авлига, ашиг сонирхлын зөрчил түүнээс урьдчилан сэргийлэх, мэдүүлэг гаргагчдад зориулсан хичээл” зэргийг Орон нутаг дахь газар, хилийн боомтуудад PDF файл хэлбэрээр дотоод сүлжээгээр хүргүүлэн албан хаагчдад бие даан судлах боломжийг хангаж ажилласан. ➤ Төв болон орон нутаг дахь газруудын ажлын байр, хилийн боомтын өрөө тасалгаанд сурталчилгааны зурагт хуудсыг тухай бүр байршуулж ажиллав. ➤ Түүнчлэн тус байгууллагын Орон нутаг дахь газрууд Авлигийн эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, энэ талаархи мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг хангах үүднээс дараахь ажлыг зохион байгуулсан байна. Тухайлбал, Өмнөд бүс дэх газар- Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн “Шударга нийгмийн төлөө хамтдаа” гарчигтай 3 төрлийн хэвлэмэл хуудас, авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөр, мэдүүлэг гаргагчдад зориулсан гарын авлагыг газрын төвийн байранд иргэд, олон нийт танилцах боломжтойгоор байршуулж ажиллалаа. Мөн хариуцан ажиллаж буй Гашуунсухайт, Шивээхүрэн боомтын мэдээллийн самбарт хэвлэмэл хуудсыг байршуулан ажилласан. Тус газрын Ёс зүйн хороо нь 2018 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр “Авилгын хор хөнөөл, түүнээс ангид байх” сэдвээр мэдээлэл өгч ажилласан бөгөөд уг хичээлд газрын төвийн 10 албан хаагч хамрагдсан.
	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Одоогоор тус байгууллагад хэрэгжиж буй төсөл байхгүй болно.
10.	Санал	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Гадаадын иргэн, харьяатын газраас Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр 2019 онд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г байгууллагын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллах
11.	Шаардагдах төсөв	10.0

12.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Одоогоор тус байгууллагад хэрэгжиж буй төсөл хөтөлбөр байхгүй болно.				
13.	Сургалтад хамруулах албан хаагчийн тоо	70				
Бүх шатны төрийн байгууллагад хамаарах						
14.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3
		100 %	3	100%	100 %	100%
15.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 7	Зорилт 10	-
		100 %	2	100 %	100 %	-
18.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (АТГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		-				